

БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Баянхонгор аймгийн худалдаа, зочид буудал,
зоогийн газрын салбарын 2016 оны танилцуулга

2017 ОН

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАА,ЗОЧИД
БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН САЛБАР
ТАНИЛЦУУЛГА**

2.1.Аймгийн нутаг дэвсгэрт худалдаа эрхлэх,үйл ажиллагаа явуулах бизнесийн орчин нөхцөл бололцоо

Аймгийн төвөөс нийслэл Улаанбаатар хүртэл 630 километр, Өвөрхангай аймаг хүртэл 210 км-ийн зайтай оршдог. Говь, Хангай, Тал хээр хосолсон, цаг агаарын эрс тэс уур амьсгалтай.

Аймгийн зах зээлийн багтаамж өргөн 85331 хүн ам, 25423 өрхтэй бөгөөд нутаг дэвсгэр 116 мянган квадрат километр, аймгийн хилийн урт 1510 километр, үүнээс БНХАУ-тай 130 километр,Өвөрхангай аймагтай 370 километр, Архангай аймагтай 390 километр, Завхан аймагтай 140 километр,Говьалтай аймагтай 480 километр тус тус хиллэдэг. Нийт өрхийн 48,4 хувь буюу 12,3 мянган өрх аймаг, сумын төвд амьдарч байна.

Нийт хүн амын 52,3 хувь нь хөдөө, 47,7 хувь нь аймаг сумын төвд амьдарч байна.

2.2.Тухайн аймгийн худалдааны салбарын үүсэл хөгжил.

Жижиглэн худалдааны газрын тоо

1947 онд эд хэрэглэгчдийн 20 хоршоо, 159 агент, 1958 онд худалдаа бэлтгэлийн 21 анги, 29 дэлгүүр, 242 агент нийт 292 худалдааны газар ажиллаж байсан.

**Жижиглэнгийн худалдаа эрхэлдэг
Цэгийн тоо.**

Он	Бүгд	Үүнээс:		
		Дэлгүүр	Агент	Эд хэрэглэгчдийн хоршоо, ХБА
1947	179		159	20
1958	292	29	242	21”

2.3. Худалдааны салбарын өнөөгийн байдал.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 164 ААНБ байгаа нь нийт аж ахуйн нэгж, байгууллагын 16,8 хувийг эзэлж байна.

2016 оны байдлаар худалдааны салбарт 3095 хүн ажиллаж байгаа бөгөөд аймгийн нийт ажиллагсдын 7,7 хувийг, Зочид буудал, зоогийн газарт 601 хүн ажиллаж байгаа бөгөөд аймгийн нийт ажиллагсдын 1,5 хувийг эзэлж байна.

**Худалдааны салбар болон зочид буудал,
Зоогийн газарт ажиллагсадын тоо**

	2012		2013		2014		2015		2016	
	Дүн	Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	Дүн	Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	Дүн	Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	Дүн	Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь	Дүн	Аймгийн нийт ажиллагсдад эзлэх хувь
Худалдааны салбарын ажиллагсдын тоо	3490	9,7	2839	7.2	2906	7,7	2611	6,7	3095	7,7
Зочид буудал, зоогийн газрын ажиллагсдын тоо	433	1,2	525	1.3	991	2,6	459	1,2	601	1,5

2016 онд худалдаа үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 31,7 хувийг эзэлж байна.

**АЙМГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ**

	2013	2014	2015	2016
Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн/сая төгрөг/	261220,3	328787,0	349375,7	347958.2
Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний дүнд эзлэх хувь	100	100	100	100
Хөдөө аж ахуй	55,8	51,5	51.7	44.6
Аж үйлдвэр, барилга	12,3	16,6	17.4	23.7
Үйлчилгээ	31,9	31,9	30.9	31.7

2016 онд худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгж байгууллагуудаас 17 ААНэгжийг түүврээр сонгон ҮСХорооноос ирүүлсний дагуу статистик мэдээнд улирал тутам хамруулсан.

Дээрх сонгогдон ирсэн Аж ахуйн нэгжийн 2016 оны нийт борлуулалтын орлого 20,9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оныхоос 2,9 хувиар өсчээ.

ХУДАЛДААНЫ ГҮЙЦЭТГЭЛ

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2016/2015
Нийт борлуулалт /сая төгрөг/	19071,1	24760,9	20379.9	20972.9	102,9



2016 онд зочид буудал, зоогийн газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгж байгууллагуудаас 16 ААН-ийг түүврээр сонгон ҮСХорооноос ирүүлсний дагуу статистик мэдээнд улирал тутам хамруулсан.

Дээрх сонгогдон ирсэн Аж ахуйн нэгжийн нийт орлого 380,7 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оныхоос 2,1 дахин өсчээ.

ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛ

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2014	2015	2016	2016/2015
Нийт орлого/сая төгрөг/	251,2	176,6	380,7	215



ДҮГНЭЛТ

Тухайн аймгийн худалдаа, зочид буудал, зоогийн газрын салбарын нийт орлого өмнөх оныхоос өссөн нь манай хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэд, бизнес эрхлэгчдийн маань зүтгэл, мөн банкны байгууллагуудын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж зээл олгож байгаа нь нөлөөлжээ.

Сүүлийн жилүүдэд аймгийн худалдаа үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдэж байгаа бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан, бизнесийн жишигт нийцсэн худалдаа үйлчилгээний төвүүд бий болсон нь аймгийн нийт иргэд өргөн сонголт, соёлтой үйлчилгээ авах бүрэн боломжийг бүрдүүллээ.

Санал:

Аж ахуй нэгж байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх

Судалгааны хамрах хугацаа: 2012-2016 оны гүйцэтгэл

Ашигласан материал:

Жилийн эцсийн мэдээ тайлан

Монгол улсын статистикийн эмхэтгэл

Статистикийн шинжилгээ судалгаа хийх гарын авлага ҮСХ 2007 он

Улсын ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл -2016 он

Ажиллах хүчний судалгааны үр дүн

www.nso.mn

www.1212.mn